

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар А-146

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД НЭМЭЛТЭЭР ИМПОРТЛОХ ХУУРАЙ СҮҮНИЙ ТОО ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор баталсан "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам", Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 08 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-д үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нийцүүлэн 2021 оны эхний хагас жилд нэмэлтээр импортлох хуурай сүүний тоо хэмжээг хавсралтад заасны дагуу тогтоосугай.
- 2.Стратегийн хүнсийг импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-ын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Л.Чой-Иш)-т, зөвшөөрлийг хууль тогтоомж, энэхүү тушаалд нийцүүлэн олгож ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн)-д тус тус даалгасугай.
- 3.Тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хуулийн хэлтэс (Э.Цолмонжаргал)-т үүрэг болгосугай.

САЙД З.МЭНДСАЙХАН